

САНГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2021.5.5

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/7/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Сангийн сайд
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор П.Чанцалдулам

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	ТЕЗ	1	1				1			
2	ТТЗ	2	2				2			
3	ЗГТС	4	1	3			1			
4	ТӨҮГ	8	8				8			
5	ТШЗ	54	43	6	5		42	1		
6	ТХН	119	57	62			52	5		
	ДҮН	188	112	71	5		106	6		

Гурав. Аудитын үр дүн

3.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
A	1	2	3	4	5	6	7
1	ТЕЗ	6	97,586.9	97,586.9	-	-	
2	ТТЗ	6	559.9	-	146.1	413.8	
3	ЗГТС	1	-	-			
4	ТӨҮГ	12	166.7	166.7		-	
5	ТШЗ	118	1,810.9	1,017.7	14.5	778.7	
6	ТХН	124	159,437.5	2,464.5	13.4	156,959.6	
	ДҮН	267	259,561.9	101,235.8	174.0	158,152.1	

3.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлбэл:

Алдаа, зөрчилтэй асуудал 1.

Тайлант онд ашиглалт гарсан, гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын үлдэгдэл нь дамжуулан зээлдэгч байгууллагуудын санхүүгийн тайлангаарх зээлийн өглөгийн үлдэгдлээс 92,235.7 сая төгрөгөөр илүү, 83,445.6 сая төгрөгөөр дутуу бүртгэлтэй бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлийн тооцоог нийлж, санхүүгийн тайланд зөв бүртгэж, тайлагнах, гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн зээлийн гэрээг байгуулахдаа тухайн зээллэгийн нөхцөлтэй уялдуулан гэрээний зориулалтыг тодорхой тусгаж, төсөвт аливаа нэмэлт төлбөрийн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтлан ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Алдаа, зөрчилтэй асуудал 2.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 65 байгууллага шилэн дансны цахим хуудсанд нийт 11,084 мэдээлэл байршуулахаас 105,288.1 сая төгрөгийн 1,898 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын 37,450.6 сая төгрөгийн 703 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хуулиар тогтоосон хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Алдаа, зөрчилтэй асуудал 3.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар эргэж төлөгдөх цэвэр зээлээс төсөвт төвлөрүүлэхээр 208,464.2 сая төгрөгийн төсөв батлагдсан боловч гүйцэтгэлээр 4000, 100000 айлын орон сууц хөтөлбөрийн эргэн төлөлт 10,158.5 сая, аж ахуй нэгж, байгууллагаас эргэн төлөгдөх 3,039.1 сая, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчаас авах 35,000.0 сая, нийт 48,197.6 сая төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төслийг бодитой тооцоололд үндэслэн төлөвлөж батлуулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Алдаа, зөрчилтэй асуудал 4.

Тайлант онд гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 9 ажлын санхүүжилт 49,270.1 сая төгрөгийг захиалагч байгууллагын санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгөнд хуримтлуулан бүртгүүлээгүй, харьяа байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайланд хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгө ангилалд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг уялдаатай нэгтгэх, ТӨХК-ууд болон бусдад оруулсан хөрөнгө оруулалтыг харьяалах төсөв захирагчийн санхүүгийн тайланд бүртгэж, нэгтгүүлэн тайлагнуулах, санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэв.

Алдаа, зөрчилтэй асуудал 5.

- Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 119 төсөл хөтөлбөр нэгтгэгдсэнээс 57 төсөл хөтөлбөрт аудит хийж, аудитаар нийт 463,970.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 304,533.4 сая төгрөгийн 114 алдааг аудитын явцад залруулж, 13.5 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 156,959.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 59 албан шаардлага хүргүүлж, 2,464.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 64 зөвлөмжийг хүргүүлсэн нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт алдаа зөрчлийн 96.8 хувийг эзэлж байна.
- Өмнөх оны тайланд бүртгэгдээгүй орхигдсон Инженер технологийн төслийн 119.2 сая төгрөгийн гадаад зээлийн ашиглалтыг тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланд нөхөж тайлагнасан байна.
- Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 119 төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 12 төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах 42 төсөл хөтөлбөр нь төслийн нэгжгүй, зөвхөн дансууд бүртгэлтэй бөгөөд эдгээр дансаар хийгдсэн ажил гүйлгээний үр дүнд бий болсон хөрөнгийн бүртгэл, тайлагналд тавих хяналт сул байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой бодлогын баримт бичгийг боловсруулж, төслийн санхүүгийн ажилтнуудыг сургалтад хамруулж, арга зүйгээр хангаж ажиллах;
2. Төслийн нэгжгүй төсөл хөтөлбөрийн санхүүжилт, төсвийг харьяалах ТЕЗ-ийн төсвийн хуваарьт батлуулж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэв.

Алдаа, зөрчилтэй асуудал 6.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүн хэсгийг хуулиар заасан хугацаанд иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, зөвхөн эдийн засгийн ангиллаарх төсвийн гүйцэтгэлийг гаргаж, нэмэлт санхүүжилтийн тайлбар, санхүүгийн тайлангийн үгэн тодруулгагүй бэлтгэсэн, төсвийн тохируулгын тайланг Сангийн сайдын тушаалаар батлагдсан маягт аргачлалын дагуу гараагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн гаргаж, толилуулж хэвших;
2. Төсвийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан журмуудын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангуудад тодруулга, танилцуулга тайлбар бэлтгэж жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай хамт ирүүлж байх зөвлөмж хүргүүлэв.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.05.05 № 1415

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ